



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 8704

Эрдэнэт


Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт хотын Хүндэт иргэн” шагналын журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 120 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

079110445

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022
оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Ээлжит
VIII хуралдааны 30/1 тогтоолын хавсралт



“ЭРДЭНЭТ ХОТЫН ХҮНДЭТ ИРГЭН” ШАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ. ЖУРМЫН ЗОРИЛГО

Орхон аймаг, Эрдэнэт хотын дээд шагналаар шагнахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ

“Эрдэнэт хотын Хүндэт иргэн” шагнал нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын нэрэмжит Орхон аймаг, Эрдэнэт хотын дээд шагнал мөн.

ГУРАВ. ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. Орхон аймаг, Эрдэнэт хотын түүхэн хөгжил, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулсан;
- 3.2. Онцгой гавъяа байгуулсан;
- 3.3. Аймаг, хотын хэмжээнд ажил хөдөлмөрөөрөө шалгарсан, нэр хүндтэй Орхон аймаг, Эрдэнэт хотод 30-аас дээш жил ажиллаж, оршин сууж буй иргэн.

ДӨРӨВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ

“Эрдэнэт хотын хүндэт иргэн” шагналд нэр дэвшүүлэх хүсэлт, тодорхойлолтыг Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын Тамгын газар хүлээн авч, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, сумдын Засаг даргын Зөвлөлийн хамтарсан хурлаар хэлэлцэн дэмжиж, дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

Үүнд:

- Нэр дэвшигчийн анкет
- Гаргасан амжилт болон үр дүнгийн талаар дэлгэрэнгүй бичсэн ажил байдлын тодорхойлолт (бүтээлийн жагсаалтын хамт)
- Өргөн мэдүүлсэн албан бичиг
- Хурлын тэмдэглэл

ТАВ. ШАГНУУЛАХ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭХ, ГАРДУУЛАХ

- 5.1. Энэхүү шагналыг Эрдэнэт хотын өдөр, Эрдэнэт хот байгуулагдсан тэгш ой болон онцгой тохиолдолд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл,

аймгийн Засаг даргын Зөвлөлийн хамтарсан хурлаар хэлэлцэнэ. Хамтарсан хурлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга удирдан явуулна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хамтарсан хурлаар нэр дэвшигч бүрийг нэг бүрчлэн хэлэлцэж хуралд оролцсон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, аймгийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Хамгийн олон санал авсан дарааллын дагуу “Эрдэнэт хотын хүндэт иргэн”-ээр шалгарсанд тооцно. Жилд 3 хүртэлх иргэнийг шагнаж урамшуулна.

- 5.2. Энэхүү шагналаар иргэнийг нэг удаа шагнана.
- 5.3. Шагнах тухай асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хамтарсан хурлын тэмдэглэлийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамж гарна.
- 5.4. Шагнал гардуулах ёслолын ажиллагааг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж, Эрдэнэт хот байгуулагдсаны тэгш ой болон Эрдэнэт хотын өдрөөр гардуулна.
- 5.5. “Эрдэнэт хотын хүндэт иргэн” шагнал нь “Эрдэнэт хотын хүндэт иргэн” медаль, үнэмлэх, 1000000 (нэг сая) төгрөгийн дагалдах мөнгөн шагналтай байна. Шагналын бүрдлийг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан бэлэн болгоно.
- 5.6. “Эрдэнэт хотын хүндэт иргэн” нас барсан тохиолдолд түүний гэр бүл (төрсөн хүүхэд)-д нэг удаагийн буцалтгүй тусламж болгон 1000000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас олгоно.
- 5.7. Дээрх шагналд зарцуулагдах хөрөнгийг орон нутгийн төсвөөс гаргана.
- 5.8. Дээрх шагналаар шагнасан иргэний зургийг аймгийн Музейд байрлуулан, “Хүндэт дэвтэр”-т бичих ажлыг аймгийн Музей; хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд алдаршуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн төв тус тус хариуцан зохион байгуулна.
- 5.9. “Эрдэнэт хотын хүндэт иргэн” нь Эрдэнэт хотын хэмжээнд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчиж, эрүүл мэндийн үйлчилгээ авах тохиолдолд дараалал харгалзахгүй үйлчлүүлнэ.
- 5.10. “Эрдэнэт хотын Хүндэт иргэн”-д Эрдэнэт хотын өдөр, аймгийн баяр наадмыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлнэ.